





ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/16

Амардалай

Төслийн удирдлагын хороо байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2, 29.1.1-ийн "б" заалт, 29.1.3-ын "а", "б" заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын санхүүжилтээр ХХААХҮЯ-аас хэрэгжүүлж буй "Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил" төслийн удирдах хороог дараахь бүрэлдэхүүнтэй томилсугай.

Дарга: Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Төслийн ажилтан

Гишүүдэд: Мал эмнэлгийн тасгийн дарга

- Мал аж ахуйн үйлдвэрлэл, малын үржил хариуцсан мэргэжилтэн
- Хүнс, ЖДҮ, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн
- Газрын даамал
- ХААН банкны эрхлэгч
- Сангууд хариуцсан нягтлан бодогч
- Баянбулаг багийн Засаг дарга
- Цахиурт багийн Засаг дарга
- Дэлгэр-Эмт багийн Засаг дарга

Хоёр: Төслийн зорилгыг удирдлага болгон, төслийн хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалтыг зориулалтын дагуу зөв зохистой, оновчтой ашиглах, төслийн үйл ажиллагааг орон нутгийн бодлого үйл ажиллагаатай уялдуулан зөвлөмжөөр хангаж, төслийн багтай хамтран үр дүнг тухай бүр тооцон тайлагнаж ажиллахыг Төслийн удирдах хороо /Засаг даргын орлогч/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.БАЯРСҮХ

4880100061